

"БУЛГАН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Булган

2022.12.03

№	Зорилт /Бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Төсөв /сая.төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Хэрэгжилт	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь	Тайлбар /Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар/
			Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Суурь түвшин	Зорилтот түвшин			
0		1	2	3	4	5	6	7	8
Бүлэг 1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого									
Зорилго 1.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.									
1.1.1	МУТЖУЧ-2.4.1, ЗГҮАХ-1.1.3	Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх	-	948.4	Нөөцийн бэлэн байдлыг эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрээр тухай бүрд тооцон гаргаж байна.	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлын хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөв болон Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар нийт 948.432.774 төгрөгийн санхүүжилтээр 13 нэр төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл, 10 автомакс, 4000 ш аюулгүй хайрцаг, 5 нэр төрлийн вирусын эсрэг эм бэлдмэл, 3024 ш ПГУ оношлуур, 1500 ш түргэвчилсэн тестийг тус тус татан авч, аймгийн хэмжээнд хариу арга хэмжээний 3 сарын нөөцийг бүрдүүлсэн	100	
Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого									
Зорилго 2.1. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.									
2.1.1	МУХТЖУЧ, ЗГҮАХ-2.1.12	Орхон сумын ЭМТ-ийн барилга барих	800.0	160.0	Зураг төслийг хийлгэсэн.	Барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой шинэ барилгын ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.29 тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 2022 онд 800.0 сая төгрөг батлагдсан. Барилгын ажлын гүйцэтгэгчээр "Талст билэг" ХХК шалгарч, төсвийн хэмнэлтийн тухай хуулиар 160 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын суурь бүрэн тавигдаж дууссан байна. 2023 онд барилгын ажил бүрэн дуусаж ашиглалтад орно.	100	
2.1.2	МУХТЖУЧ, ЗГҮАХ-2.1.12	Баяннуур сумын моргийн барилга шинээр барих, Бугат, Сэлэнгэ сумын моргийн барилгын зураг төсөв хийлгэх	100.0	100.0	-	Барилга баригдаж, зураг төслийг хүлээн авсан байна.	Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн моргийн барилгыг орон нутгийн төсвийн 80.0 сая төгрөгөөр "Баян улаан констракшн" ХХК барьж ашиглалтад оруулсан. Бугат, Сэлэнгэ сумын моргийн барилгын зураг төсвийг "Өрнөх гүнт" ХХК 20 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	100	
2.1.3	МУХТЖУЧ, ЗГҮАХ-2.1.12	АНЭ-ийн дотрын тасагт их засварын ажил хийх	218.3	193.8	2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гурванбулаг, Сайхан, Рашаант, Хишиг-Өндөр, ЭМТ-д их засвар хийсэн.	Засвар хийж дууссан байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн их засварын ажлыг орон нутгийн төсвийн 193.8 сая төгрөгийн санхүүжилтээр "Тана орд" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 7 дугаар сард хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд эмч, эмнэлгийн ажилчдын ажлын байрны орчин нөхцөл сайжирч, хэвтэн эмчлүүлж байгаа иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 11.0 хувиар дээшилсэн үзүүлэлттэй байна.	100	
2.1.4	МУХТЖУЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.12	Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, бүрэн камержуулан аюулгүй байдлыг сайжруулах	500.0	908.9	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дурангийн хагалгааны тоног төхөөрөмжөөр хангасан.	Тоног төхөөрөмжийн хангалтыг 88 хувьд хүргэнэ.	Аймгийн эрүүл мэндийн салбар 2022 онд нэн шаардлагатай 48 нэр төрлийн 850.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Үүний 78.0 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, 22.0 хувь нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн. Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй "Эх хүүхдийн эрүүл мэнд" төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, яаралтай тусламжийн тасгийг 58.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангав. 2022 онд тоног төхөөрөмжийн стандарт хангалтын түвшин аймгийн Нэгдсэн эмнэлэгт 91.0 хувь, сумын Эрүүл мэндийн төвүүдэд 88.0 хувьтай байна. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалт суурь түвшнээс 4.5 пункт, зорилтот түвшнээс 1.5 пунктээр тус тус нэмэгдэж, 89.5 хувьд хүрсэн.	100	
2.1.5	МУХТЖУЧ-2.2.4, ЗГҮАХ-2.1.12	Багийн эмч нарыг "Mobile" тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	60.0	86.8	-	10 багийн эмчийг "Mobile" тоног төхөөрөмжөөр хангана.	Улсын төсвийн 75.6 сая, орон нутгийн төсвийн 11.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 эрүүл мэндийн байгууллага /Баян-Агт, Бугат, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв, Булган сумын "Цоожад", "Эмийн цэцэглэн" өрхийн Эрүүл мэндийн төв/ мобайл тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Үүний үр дүнд хөдөөгийн алслагдсан багийн иргэд эрүүл мэндийн үйлчилгээг цаг алдалгүй хурдан шуурхай авах нөхцөл бүрдэж, багийн эмч нарт зайнаас оношилгоо эмчилгээг хийх боломж бүрдэж байна.	100	
2.1.6	МУХТЖУЧ-2.2.4, ЗГҮАХ-2.1.4.4	Эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн машинаар үе шаттай хангах	105.0	244.8	Нэгдсэн эмнэлэг, Орхон, Гурванбулаг, Баян-Агт сумын ЭМТ-д Улсын төсөв, хандив тусламжаар авто машин олгосон.	Нэгдсэн эмнэлэг, Хишиг-Өндөр, Хангал сумын эмнэлгийн машиныг шинэчилнэ.	2022 онд улсын төсвийн 89.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хангал, Хишиг-Өндөр сумдын Эрүүл мэндийн төвд УАЗ-22069 маркийн автомашин, Эрүүл мэндийн яамнаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт 155.0 төгрөгийн төсөвт үнэ бүхий Land Cruiser 78 загварын туулах чадвар өндөртэй эмнэлгийн түргэн тусламжийн автомашин олголоо. Мөн Рашаант сумын Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай байгаа автомашины саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Энэ онд эрүүл мэндийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлт 90.0 хувьд хүрч, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хурдан шуурхай хөргөх бэлэн байдал хангагдав.	100	
2.1.7	МУХТЖУЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлэх	240.0	-	-	4 суманд сууц барина.	Хишиг-Өндөр суманд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан орон сууцны төсөл хэрэгжихээр болж, зураг төсөв нь хийгдээд байна.	0	Санхүүжилтгүй
2.1.8	ЗГҮАХ-2.1.14	Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох	140.0	-	-	Гурванбулаг, Орхон суманд стандарт хангасан ариун цэврийн байгууламж бий болгоно.	2023 онд шинээр ашиглалтад орох Дашинчилэн, Орхон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөвт ариун цэврийн ерөөтэй байхаар тусгасан.	30	
Зорилго 2.2. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.									
2.2.1	МУХТЖУЧ-2.1.3, ЗГҮАХ-2.3.4	Эх хэл, эх түүх, байгалийн ухаан, техник технологи, гадаад хэл, нийгмийн ухаан, спорт, урлагийн боловсрол олгох ажлыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах	25.0	100.0	Орчин, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.	5 сургуулийн сургалтын орчин сайжирна.	Байгалийн ухааны сургалтын орчныг сайжруулахад "Тогтвортой хөгжлийн боловсрол 2" төслөөс 60.0 сая, орон нутгийн төсвөөс 20.0 сая, нийт 80.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Төслийн хүрээнд Булган сумын Эрдмийн Өргөө цогцолбор сургуульд "Эко номын сан", Могод суманд "Цахим танхим", Хишиг-Өндөр сум "Ногоон оффис", Хялганат тосгон "Эко зуслан" төслүүдийг хэрэгжүүлж байна	100	

2.2.2	МУХТЖҮЧ-6.4, ЗГҮАХ-	"Эко Зуслан", "Туршилтын талбай" байгуулах ажлыг эрчимжүүлэх, "Тогтвортой хөгжлийн боловсрол-2" төслийг хэрэгжүүлэх	20.0	37.5	Бүх сургууль, цэцэрлэг туршилтын талбайтай. "Эко зуслан" 2 байна.	Үйл ажиллагааг 30 хувиар идэвхжүүлсэн байна.	Хангал сумын Хялганат тосгонд 50 хүүхдийн хүчин чадалтай Эко зуслангийн ажлыг дэмжиж орон нутгийн төсвөөс 37.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээр хоолны заал, хөвгүүдийн амрах байрны зарим засварыг бүрэн дуусгаж, эхний ээлжийн амрагч хүүхдүүдийг хүлээн авч сургалт, хөгжлийн үйл ажиллагааг сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн. Мөн аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 20 сургууль, 20 цэцэрлэг өөрсдийн нөөцөд тулгуурлан туршилтын талбайг байгуулсан нь нийт сургууль, цэцэрлэгийн 91.0 хувийг эзэлж байна. "Тогтвортой хөгжлийн боловсрол-2" төслийн хүрээнд 9 сургууль, 9 цэцэрлэг олон улсын "Эко сургууль" хөтөлбөрт хамрагдсан. Тухайлбал: Хялганат тосгоны сургууль 7000 суулац модыг тарьж бусад сургуулиуд мод тарих, байгаль орчноо хайрлах, хамгаалах зэрэг нийгэм болоод байгаль орчинд тустай эко сургалтын хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байна. Уг төсөлд давхардсан тоогоор 18000 орчим багш, ажилчид, эцэг эх, сурагчид хамрагдаад байна. Төслийн үр дүнд хүүхэд залуучууд, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан хаагчдад байгаль экологийн зөв зохистой хэрэглээг таниулсан, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.	100	
2.2.3	МУХТЖҮЧ-2.1.5, ЗГҮАХ-2.3.6.3	Сурлага, хүмүүжил, төлөвлөөрөө манлайлагч сурагч, оюутанд 100 хувь хүртэл "Аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг" олгох	120.0	244.0	-	30 сурагч, оюутанд тэтгэлэг олгоно.	"Аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох журам"-ын дагуу 2022 оны хичээлийн жилд 2022 онд нийт 30 хүүхдэд 140.0 сая төгрөгийн тэтгэлэг, 30 хүүхдэд 104.0 сая төгрөгийн дэмжлэг, 16 багшид 22.0 сая төгрөгийн урамшуулал олгож өмнөх оноос 48.0 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Тухайлбал: "Булган хангайн хүүхдүүд 2022" урлагийн наадамд оролцсон төгсөх ангийн шилдэг 5 сурагчид МУ-ын Консерваторт 100 хувийн тэтгэлэгтэй суралцах эрх, Спортын өндөр амжилт гаргасан 5 оюутанд Засаг даргын нэрэмжит 100 хувийн тэтгэлэг тус тус олголоо. Мөн 2022 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр тэргүүлсэн 20 оюутанд сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг, Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан сурагч, бэлтгэсэн багш болон улсын чанартай олимпиадад амжилт гаргасан багш тус бүрд 1.0 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Беларусь улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 3 оюутныг 100 хувийн тэтгэлэгт хамруулж, Улаанбаатар хотод суралцаж буй оюутан залуустай "Хамтын ажиллагаатай Булган" арга хэмжээний хүрээнд уулзалт хийж 3 оюутанд Булган аймагт ирж ажиллах, амьдрах нөхцөлтэйгөөр 100 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгож, цаашид хөдөө орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтэн, хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор 30 оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлээ. Цаашид Бүгд Найрамдах Солонгос Улсад 2023 онд сум бүрээс 1 оюутан суралцуулах гэрээг байгуулж, цаашид дотоодын болон гадаадын их, дээд сургуулиудад оюутан залуусыг суралцуулах томоохон алхам боллоо.	100	
2.2.4	МУХТЖҮЧ, ЗГҮАХ-2.3.4.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлж, суралцах орчин нөхцөл, дэд бүтцийг бүрдүүлэх	20.0	-	Системд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 78 хүүхэд байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	Аймгийн хэмжээнд Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 156 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс ерөнхий боловсролын сургуульд 71, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй 12, сургуулийн өмнөх боловсролд 17 хүүхэд, нийт 100 хүүхэд суралцаж байгаа нь хамрагдвал зохих хүүхдийн 64.1 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс хамран сургалт 22.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100	
2.2.5	МУХТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ-2.3.12	Боловсролын салбарт цахим платформуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх	10.0	356.8	Холбогдох веб сайтуудыг ашиглаж байна.	Шинэ платформуудыг цахим нэвтрүүлнэ.	Боловсролын салбарт мэдээллийн технологи, цахим платформ, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх, багш ажилчид, суралцагчдыг цахим орчинд ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлэхээр ерөнхий боловсролын 11 сургууль болон Боловсрол, шинжлэх ухааны газрын "Багшийн хөгжлийн төв" д 157.0 сая төгрөгөөр ухаалаг дэлгэц, 3 сургуульд "Студийн тоног төхөөрөмж"-д 57.0 сая төгрөг, Бүгд найрамдах Солонгос улсын Дэчон хотын Боловсролын газраас Булган сумын 1 дүгээр сургуульд 142.8 сая төгрөгийн "Smart class" цахим кабинетийг шинээр тохижуулан нийт 356.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран нээлттэй даалгаврын сангийн системд энэ онд ерөнхий боловсролын 22 сургууль бага боловсролд 1750, суурь боловсролд 3300, бүрэн дунд боловсролд 2000 даалгавар боловсруулан шивж оруулахаар сан бүрдүүлэн ажиллаж байна. "Ээлжит хичээлийн цахим контентын сан"-д 282 цагийн хичээл байршууллаа. БШУГ-ын албан ёсны вэб сайтад багш нарын цахим хичээл байршуулах ажил хийгдэж байгаа ба боловсролын динамик сайт, цахим платформтой холбож өгсөн. ЕБС-иуд asky.mn болон үнэлгээний даалгаврын нэгдсэн сангийн iteambank.eec.mn цахим системийг ашиглах гэрээг хийж, Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль "Амжилт-2.0" системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд багш нарын цахим орчин нөхцөлд ажиллах боломж, чадвар 12.0 хувиар, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж 23.0 хувиар ахисан амжилттай байна.	70	
2.2.6	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.3.1	Булган нутгаас төрөн гарсан эрдэмтдийг алдаршуулж, Улсын Англи хэлний олимпиадыг зохион байгуулах	50.0	18.9	-	Улсын Англи хэлний олимпиадыг зохионо.	"Англи хэл сурч хамтдаа хөгжье" сарын аяны хүрээнд АЗДТГ, АНУ-ын элчин сайдын яам, "Хотол Булган" ТББ-тай хамтран XI-XII ангийн 28 сурагч, 18 багш нарын дунд түвшин тогтоох "Англи хэл"-ний олимпиадыг зохион байгуулж 11-12 дугаар ангийн сурагчдын англи хэл дээр эссэ бичих чадвар сайжирч, үгийн баялаг нэмэгдэж, 7-10 дугаар ангийн сурагчид англи номыг уншиж, бүтээлчээр тэмдэглэл хөтлөх аргад суралцаж, англи хамт олны оролцоо, идэвх санаачилга нэмэгдсэн байна. Мөн Оросын шинжлэх ухаан, соёлын төвтэй хамтран Орос хэл, соёлын хангайн бүсийн 5 аймгийн олимпиад, сургалт семинарыг зохион байгуулж, 48 сурагч, багш нарыг хамруулж ажиллалаа. Тус арга хэмжээнд 3.9 сая төгрөг зарцуулсан. Монгол дахь Америкт төгсөгчдийн холбооноос Америкт сурах боломжууд, төгсөгчдийн түүх, тэтгэлэг танилцуулга уулзалт сургалтад 9-12 дугаар ангийн 300 гаруй суралцагч хамрагдлаа. 2022 оны 9 дүгээр сараас эхлэн TESOL мэргэжлийн англи хэлний багш Шериф Смайльтай хамтран англи хэлний багш нарыг чадавхжуулах, ярих, бичих, сонсох, унших чадварыг хөгжүүлэх, сурагчдын англи хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх ярианы клуб, иргэд, төрийн албан хаагчдад ярианы клуб, анхан шатны сургалт зохион байгуулан ажиллаж, 15.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, шаардлагатай материаллаг баазыг ханган ажиллаж байна. Тус сургалтад тогтмол 35 багш, 150 гаруй иргэд, төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн 60 гаруй сурагч цахим болон танхимгаар хамрагдаж байна.	50	

2.2.7	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Булган сумын 3-р цэцэрлэг, Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах, Булган сумын 4-р цэцэрлэг, Хангал сумын цэцэрлэгийн барилгыг эхлүүлэх	2,950.0	1545.7	Стандарт шаардлага хангахгүй, хүчин чадал хэтэрсэн.	График, төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлсэн байна.	Булган сумын 3-р цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын явц 90%-тай явагдаж байгаа бөгөөд 2022 оны үлдэгдэл 262.5 сая төгрөгөөр гадна тогооны барилга, Бохирын цооногын ажил хийгдэж байна. Гурванбулаг сумын "Солонго" цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг "Баатар шүтээн уул" ХХК гүйцэтгэн ашиглалтад өгөөд байна. Булган сумын 4-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлын нээлттэй тендэрт "Их Азар" ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлаа эхлүүлээд байна. Хангал сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр "Тэнгэрийн хишиг" ХХК шалгарч 1.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан энэ онд 700.0 сая төгрөгөөр барилгын төмөр бетон арагт бүтээц, хаалга цонх, дээврийн хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100	
2.2.8	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Хутаг-Өндөр, Дашинчилэн сум 150 ортой сургуулийн дотуур байрны барилга шинээр барих	2,300.0	2,300.0	Стандарт шаардлага хангалтгүй, хүчин чадал хэтэрсэн.	Барилгын ажлыг эхлүүлж, төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Булган сумын 4-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлын нээлттэй тендэрт "Их Азар" ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлаа эхлүүлээд байна. Хангал сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр "Тэнгэрийн хишиг" ХХК шалгарч 1.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан энэ онд 700.0 сая төгрөгөөр барилгын төмөр бетон арагт бүтээц, хаалга цонх, дээврийн хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100	
2.2.9	БАХҮЧ-1.1.4, ЗДМХ-1.2.5	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	300.0	466.2	Булган сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засвар хийгдсэн.	Бүрэгхангай, Могод сумын дотуур байрны засварын ажил хийгдэнэ.	Могод сумын ерөнхий боловсролын сургуулийн 80 хүүхдийн ортой дотуур байрны барилгын засварын ажлыг "ЭПО" ХХК 269.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв. Бүрэгхангай сумын дотуур байрны засварын орон нутгийн төсвийн 196.3 сая төгрөгийн санхүүжилтээр "Юникорн менежмент" ХХК хийж гүйцэтгэн хүлээн авсан.	100	
2.2.10	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Булган сумын 1-р цэцэрлэгт их засвар хийх	200.0		Стандарт хангалтгүй.	Булган сумын 1 цэцэрлэгт их засвар хийнэ.	Булган сумын 1-р цэцэрлэгийн барилгын засварын ажлыг орон нутгийн төсвийн 396.0 сая төгрөгөөр "Сувдан элс" ХХК хийж гүйцэтгэлээ.	100	
2.2.11	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Сэлэнгэ, Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны их засвар хийх	480.0	478.0	Стандарт хангалтгүй.	Их засвар хийгдэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.	Орхон сумын сургуулийн барилгын засварын ажилд 2022 оны орон нутгийн төсвийн 228.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Ди ти и эм строй" ХХК шалгаран ажиллаж, ашиглалтад оруулаад байна. Сэлэнгэ сумын сургуулийн барилгын их засвар 496.0 сая төгрөг төлөвлөснөөс 2022 онд 250.0 сая төгрөгийг шийдвэрлэн тухайн батлагдсан хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгын дотор цахилгаан, сантехник, заслын ажлын гүйцэтгэгчээр "Хөх сэрхийн мандал" ХХК ажилласан.	100	
2.2.12	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Булган суманд цэцэрлэгийн зуны бүлэг ажиллуулж, 8-аас доошгүй сумын гэр цэцэрлэгийг шинэчлэх, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжих	11.0	16.5	Хөдөөгийн багуудад 44 гэр цэцэрлэгт 980 хүүхэд хамрагдсан.	2 сумын гэр цэцэрлэгийг шинэчилж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Орхон сумын "Ар булаг", "Халиун", "Бүхт" багт зуны нүүдлийн гэр цэцэрлэг, Бугат сумын цэцэрлэг, Орхон суманд гэр цэцэрлэг ажилласан. Зуны цэцэрлэгийн 34 бүлэг ажиллаж 680 хүүхэд хамруулсан. Төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан гэр цэцэрлэг шинэчлэх ажил хийгдээгүй.	0	санхүүжилтгүй
2.2.13	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Боловсролын байгууллагуудыг цахим тоног төхөөрөмж, техник, хэрэгсэл, хатуу, зөөлөн эдлэл, гал тогооны тоглоом, наадгайгаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	225.0		Стандарт шаардлага хангалтгүй. Тоног төхөөрөмж дутагдалтай.	Үе нэмэгдүүлнэ.	Цэцэрлэг, сургуулийн тоног төхөөрөмж, тоглоом, тохижилтын ажил өмнөх оноос 52.4 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Ерөнхий боловсролын сургуулийн нийт хөрөнгө оруулалтын 44.0 хувь нь улсын төсвөөс, 15.5 хувь нь орон нутгийн төсвөөс, 3.5 хувь нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 14.2 хувь нь байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрөөс, 6.3 хувь нь иргэдийн хандив тусламжаар, 3.7 хувь нь аж ахуйн нэгжийн хандиваас бүрдсэн байна. Мөн энэ онд 20 сургуульд математикийн кабинет байгуулахад 200.0 сая, 11 сургууль, Боловсрол, шинжлэх ухааны газрын "Багшийн хөгжлийн төв"-д 157.0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, 3 сургуульд 57.0 сая төгрөгөөр студийн тоног төхөөрөмж, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдийн ажлын байрны тоног төхөөрөмжийг сайжруулахад 20.0 сая төгрөг, нийт 434.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэлээ. Цэцэрлэгийн өргөтгөл, шинэ барилга өмнөх оноос 36.0 хувиар, их засвар 37.7 хувиар буурч, тоног төхөөрөмж 21.0 хувиар нэмэгдэж, сургалтын таатай орчин бүрдсэнээр хүүхэд бүрт хүртээмжтэй, танхим, цахим технологид суурилсан мультимедиа технологид суурилсан интерактив хичээл, хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт нийцсэн сонирхолтой хичээлүүд заагдаж, багш нарын мэргэжил арга зүй, хичээлийн бэлтгэл, идэвх сайжирч, хүртээмж 35.0 хувиар ахисан үзүүлэлттэй байна.	100	
2.2.14	МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.11	Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг орон нутгийн онцлолт нийцүүлэн сайжруулж, шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах	50.0		Тоног төхөөрөмж, хэрэглэл материал хангалтгүй.	5 сургууль, 5 цэцэрлэгийг тоног төхөөрөмжөөр хангана.	Булган сумын 3 дугаар сургуулийн хөгжмийн кабинетыг засварлаж, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 20 ширхэг морин хуураар материаллаг баазыг бэхжүүлэн, 60 хүүхдийн чуулга хичээллүүлж байна. Булган сумын 1 дүгээр сургуульд 142.8 сая төгрөгийн "Smart class" цахим кабинетыг шинээр тохижуулан Булган сумын "Эрдмийн Өргөө" цогцолбор сургуульд хүүхдийн ширээ сандал, хөгжмийн сандал, самбар, шкаф зэрэг 20.0 сая төгрөгийн тохижилтын ажил хийгдэв. Мөн Дүрслэх урлагийн кабинетыг Булган сумын Эрдмийн Өргөө цогцолбор сургууль, Бугат, Дашинчилэн, Сэлэнгэ, Хишиг-Өндөр суманд байгуулж, бүх сургуулийн 1 дүгээр ангийн хүүхдэд зориулсан бие бялдрын сорил авах хэрэгсэл дэхүүнээр хангагдлаа.	100	

Зорилго 2.3. Хөдөлмөр эрхлэлт. Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.3.1	МУТЖҮЧ-2.6.1 ЗГҮАХ-2.5.4	Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулж, салбар хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх	3.0	15.0	ХНЗ-ийн 3 талт гэрээний хэрэгжилт 90.0 хувь, салбар хороонд тодорхой хэмжээний төсөв хөрөнгө батлагдаж, үйл ажиллагаа нь тогтворжсон.	Хэлэлцээрийн хэрэгжилт 90-ээс доошгүй хувь хэрэгжсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрийг 13 суманд байгуулж, хэлэлцээрт заагдсаны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд эрүүл мэндийн салбарт хамтарсан үзлэг шалгалтын ажлыг явуулж, үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн 3 талын төлөөллийг чадавхжуулах сургалтыг 4 дүгээр сэдэв цахим аргаар зохион байгуулж, сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн 87 гишүүнийг хамруулан мэдлэг, мэдээллийг хангав. 2022 онд 3 талын төлөөлөл хамтран "Хөдөлмөрлөх эрх, тулгамдсан асуудал, шийдийн гарц" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн 3 талт хэлэлцээрийн хэрэгжилт 93.0 хувьтай байна. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгаас 15.0 сая төгрөг зарцуулсан байна.	100	
2.3.2	МУТЖҮЧ-2.6.1 ЗГҮАХ-2.5.10, 2.5.11	Их дээд сургууль, МСҮТ-ийг төгссөн залуу боловсон хүчний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх /гарааны бизнесийг дэмжих/	10.0	10.0	1 бүлэгт 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	1-2 бүлэгт дэмжлэг үзүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж байгаа 15-34 насны шинэ залуу хүний нөөцийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах зорилгоор залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох Старт-ап арга хэмжээнд 6 багийн 23 оролцогч хамрагдаж, бизнесийн шинэ санаагаар өрсөлдсөн. Тус арга хэмжээний хүрээнд 2 шатны шалгуур хангасан багт эргэн төлөх нөхцөлгүй 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн байнгын 2 ажлын байр шинээр бий болголоо. Мөн улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Оролцоо" төсөлд хамрагдах хүсэлтэй 18-34 насны залуусыг цахимаар бүртгэж, 27 залуу хамрагдаж, 8 иргэн байнгын ажлын байртай болоод байна.	100	

2.3.3	МУТЖУЧ-2.6.2 ЗГҮАХ-2.5.14	Ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилд зуучлан жил бүр 1300-аас доошгүй ажлын байрыг бий болгох	100.0		2021 онд нийт 1608 иргэн ажлын байраар хангагдсанаас байнгын ажлын байранд 208, улирлын ажлын байранд 415, түр ажлын байранд 985 иргэн ажиллаж байна.	300 байнгын ажлын байр 200 улирлын ажлын байр, 800 түр ажлын байрыг бүртгэнэ. Нийт 1300	2022 онд 1300 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөснөөс давхардсан тоогоор 880 ажлын байрны захиалга авч "Сайхан Монгол" телевиз болон зарын цэгүүд, цахим хуудсанд байршуулан сурталчилж ажилласнаар 1250 шинэ ажлын байр бий болж, гүйцэтгэл 96.1 хувьтай байна. Үүнээс байнгын ажлын байранд 275, улирлын ажлын байранд 220, түр ажлын байранд 755 иргэн ажиллаж байна. Нийт 742 иргэнийг ажилд зуучлахаар төлөвлөснөөс ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 742 иргэн зуучлагдаж, байнгын ажлын байранд 300, улирлын ажлын байранд 92, түр ажлын байранд 350 иргэн ажиллаж, гүйцэтгэл 100 хувьтай байна.	100		
2.3.4	МУТЖУЧ-2.3.2 ЗГҮАХ-2.5.9	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх	300.0	749.0	2021 онд нийт 78 хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдэд 359.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.	50-аас доошгүй иргэн, ААН-д зээл олгоно.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч 104 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмж авах, ажлын байраа өргөтгөхөд нь зориулж 749.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний орлого 100.0-200.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 26 шинэ ажлын байр бий болсон байна.	100		
Зорилго 2.4. Нийгмийн хамгаалал. Нийгмийн зорилот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жөндөрийн тэгш байдлыг хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.										
2.4.1	МУТЖУЧ-3.1.4, 3.1.3 ЗГҮАХ-2.5.7	"Зорилот өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр"-ийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулж хэрэгжүүлэх	100.0		Нийт өрхийн 29.0 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой байна.	Жил бүр 300-аас доошгүй өрхийн амьжиргаа дээшилсэн байна.	Аймгийн засаг даргын нэрэмжит "Хүрч үйлчлель" нийгмийн салбарын байгууллагуудын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн 8 сумын 2600 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл өгөх, төсөл хөтөлбөрт хамруулах, ажлын байраар хангах, нийгмийн даатгалд хамруулах зэрэг ажлыг зохион байгууллаа. Тухайлбал: Зорилот бүлгийн 326 өрхөөс хөдөлмөрт бэлтгэх сургалтад 248 иргэнийг хамруулж, 245 иргэнийг байнгын болон түр ажлын байртай болгосноос давхардсан тоогоор түр ажлын байранд 172, байнгын ажлын байранд 60 иргэн ажиллаж байна. Харин хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт 13 иргэн хамрагдаж, ажлын байраар хангагдсан. Орон гэргүй болон байшин засаж сэлбэх шаардлагатай 3 өрхийг дэмжиж, аймаг орон нутгийн болон төрийн бус байгууллагын дэмжлэг тусламжид 128 өрхийг хамрууллаа. Эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоонд 800 гаруй иргэн хамрагдаж, 52 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулав. 2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор амьжиргааг нь дээшлүүлэхээр сонгогдсон өрхийн 90.5 хувь буюу 295 өрхөд хүрч ажилласан. Үүний үр дүнд амьжиргааг нь дэмжихээр сонгож авсан өрхийн 80 гаруй хувьд тодорхой хэмжээний ахиц өөрчлөлт гарч, өрхийн орлого нэмэгдсэн байна.	90		
2.4.2	МУТЖУЧ-2.3.5 ЗГҮАХ-2.5.8	Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, санаачлагуудыг дэмжих	10.0		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 61.1%-иар, эерчлийн хэргийн тоо 19,7%-иар буурсан байна.	Гэр бүлийн хүчирхийллийн тоо буурсан байна.	Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн албан чиглэл, аймгийн Засаг даргын албан даалгавар тус тус гаргаж, сумд болон салбар байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Боловсрол, шинжлэх ухааны газар хамтран 16 сум, 1 тосгонд зөвлөн туслах ажлыг 2 удаа зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн. Сумдын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг ажлын байранд нь 2 удаагийн давтамжтай 155 гишүүнийг, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр хамтарсан багийн кейс менежерүүдийн 2 өдрийн давтан сургалтад 50 нийгмийн ажилтныг тус тус хамруулсан. Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл"-ийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 90 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн тэргүүнүүд оролцлоо. Зөвлөгөөний үр дүнд 21 байгууллага хүүхдийн өрөө тохижуулан, бүх сургууль цэцэрлэг хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. 292 өрх "Миний гэр-Аюулгүй орчин" үнэлгээний хуудсаар гэрийн орчноо үнэлж, хүүхдэд аюул учруулж болох 195 эерчлийг арилган гэр бүлийн орчноо хүүхдэд ээлтэй болгосон байна. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан сургууль, цэцэрлэгүүд 1034 эцэг эхэд хүмүүжлийн зөв арга сургалтыг зохион байгуулсан. Түр хамгаалах байранд 2022 оны жилийн эцсийн байдлаар 49 хүүхэд, 11 насанд хүрэгч 405 хоногийн үйлчилгээ авсан байна. Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн хор хөнөөлийн талаар хөдөөгийн багийн иргэдэд хууль эрх зүйн ойлголт өгөх "Эрсдэлээс сэргийлэх" арга хэмжээг хууль хүчний байгууллагуудтай хамтран 8 сумын 17 багийн 1211 иргэнд хүргэж ажиллалаа. Дээрх ажлуудын үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн тоо өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100		
2.4.3	МУТЖУЧ-2.3.4 ЗГҮАХ-2.5.8	ХХҮГ-ын харьяа ахмадын амралтын барилгад засвар хийж, шаардлагатай зарим тоног төхөөрөмжөөр хангах	17.0	35.6	Барилгын хана таазанд анцав, цууралт үүсэн, хойд хэсгээрээ суулт үүссэн их засвар хийх зайлшгүй шаардлагатай.	Их засварын зураг төсвийг хийлгэнэ.	2022 онд аймгийн Ахмадын өргөөний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж аймаг, орон нутгийн зүгээс 25.0 сая төгрөгөөр шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, зарим засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн 10.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүжгийн заалны тохижилтыг хийж, хөгжим хэрэгслээр хангасан байна.	100		
2.4.4	МУТЖУЧ-3.1.4 ЗГҮАХ-2.5.13	ХХҮГ-ын харьяа Сувиллын яслийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах	32.0			Зураг төсөв хийлгэсэн байна.	Сувиллын яслийн барилгын зураг төсвийг Улаанбаатар хотын Энхийн жаргалан контракшн ХХК-иар гүйцэтгүүлж дуусгасан ба техник, эдийн засгийн үнэлгээг боловсруулан экспертизээр батлагдсан. Барилгын төсөвт өртөг 2.9 тэрбум төгрөгөөр болсон ба хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна.	100		
2.4.5	МУТЖУЧ-2.5.8 ЗГҮАХ-2.5.9	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах "Хүчирхийлэлээс хамгаалах түр байр"-ны зардлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх	30.2	48.0	Түр байрны барилгын ажил эхэлж, гүйцэтгэл 80 хувьтай байна.	Түр байрны барилгын ажлыг үргэлжүүлж, дулаан бохирын шугамын холболт хийсэн байна.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах байрны барилгын сан техникийн холболтын ажлыг "Гурван Уулын хишиг" ХХК-иар гүйцэтгүүлж, улсын комисс хүлээн авсан. Тус байрны барилгын ажил дууссан бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлаас бүрэн ашиглана.	100		
2.4.6	МУТЖУЧ-2.3.2 ЗГҮАХ-2.5.8	Хүүхдийн Жаргалант зуслангийн захиргаа удирдлагын байрыг барих, хэсэгчилсэн зураг төсвийн дагуу барилга байгууламжуудыг барих	225.0	255.0	Жаргалант зуслангийн эхний шатны ажлыг 665.0 сая төгрөгөөр 60 хувьтай хэрэгжиж байна.	Эхний шатны ажил 100 хувь	Жаргалант зуслангийн хоол, сургалтын танхим бүхий захиргаа удирдлагын байрны барилгын ажлыг улсын төсвийн 920.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эко эрдэнэс үүр" ХХК гүйцэтгэн барилгын ажил 85.0 хувьтай байна. Барилгын үлдэгдэл санхүүжилт болон дараагийн шатны хөрөнгө оруулалтыг 2023 оны улсын төсөвт тусгуулаад байна. Зуслангийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 4 хотхон, ерөнхий дэд бүтэц, орчны тохижилтын зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн.	100		

Зорилго 2.5. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.									
2.5.1	МУТЖУЧ-5.3.2, ЗГҮАХ-2.6.2	Соёлын биет бус өв тээгчдийн судалгааг шинэчлэх, шинэ өв тээгчдийг илрүүлэх, бүртгүүлэх, өвлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	5.0	-	Соёлын өв тээгчдийг урамшуулах тогтолцоо байхгүй.	Мэдээллийн санд оруулахаар төлөвлөсөн соёлын өвийн мэдээллийн 10 хувийг бүрдүүлнэ.	Соёлын биет бус өв тээгчдийн бүртгэлийн ich.mongolulv.mn шинэ системийг нэвтрүүлэн өвлөн уламжлагчдын анхан шатны тооллого хийгдэж эхэлсэн. 2022 онд 3 суманд биет бус өв тээгч 12 хүний мэдээллийг шинээр бүртгэн баримтжуулав. Соёлын биет бус өвийг өвлүүлэх зорилгоор уртын дууг 54, морин хуурыг 36, гар урлалыг 34, шайга харвааг 10 хүн тус тус сургаж байна. Үндэсний өв соёлын үнэт зүйлийг хойч үедээ сурталчлан таниулах, өвлөн уламжлагч нараа алдаршуулах өв тээгчийг илрүүлэх зорилгоор өвлөн уламжлагч нарын сурталтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 7-10 дугаар ангийн 321 сурагчийг хамруулсан. Соёлын биет өвийн ich.mongolulv.mn мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх тооллогын ажил 92.5 хувьтай хийгдэж байна. Мөн аймгийн хэмжээнд түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг олон жил хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулан, тогтмол харж, хамгаалж байгаа 24 иргэн, соёлын өв тээгч 16 хүнд аймгийн Засаг даргын зүгээс ТАПАРХАП олгосон	100	
2.5.2	МУТЖУЧ-1.1.4, ЗГҮАХ-2.6.3	Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах	50.0	79.0	Аймгийн хэмжээнд улсын хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл 25 байна.	Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 50 хувийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулна.	Улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас 21 дурсгалыг орон нутгийн хүмүүстэй хамтран ажиллах гэрээ байгуулан эзэнжүүлэн хамгаалалттай болгов. Мөн "Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын судалгааны түүхэн тойм" сэдвээр судалгааны ажил хийж олон нийтэд цахимаар сурталчилж байна. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт "Хүйс толгойн бичээс" бүхий гэрэлт хөшөөг залах ёслолыг Могод суманд зохион байгуулсан. "Цогт тайжийн Цагаан байшин" дурсгалыг орон нутгийн төсвөөс 79.0 сая төгрөгөөр хашаажуулах ажил хийгдсэн.	100	
2.5.3	ЗДМХ-1.4.5	Булган нутгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын ажлыг Орхон-Туул, Эг-Сэлэнгэ, Хануй-Хүннүгийн дурсгалыг түшиглэн зохион байгуулах	10.0	-	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг түшиглэн дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого байхгүй.	Аймгийн соёлын аялал жуулчлалын маршрут бий болгоно.	Аймгийн нутагт дэвсгэрт байгаа соёлын өвүүдийг гадаад, дотоодын жуулчдад сурталчлах зорилгоор соёлын аялал жуулчлалын маршрут гаргалаа. Мөн цахим орчинд "Булганаар аялагчид" нийтийн булэг үүсгэн аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг сурталчлан ажиллаж байна. Улсын хэмжээнд зохион байгуулсан Авто-рали уралдааны нээлтийг Цогтын цагаан байшин орчим газарт зохион байгуулж, жуулчдад зориулсан түүхийн дурсгалт газруудын гарын авлагыг 300 хүнд тараан сурталчиллаа. Шороон бумбагар бунхант булшны хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын талаар Соёлын яам болон ТИКА олон улсын байгууллагад албан бичиг хүргүүлсэн. Хар бүхэн музейд дэвээр, дотор засалт, хашааны их засварыг хийж хүлээн авсан.	100	
2.5.4	МУТЖУЧ-1.1.2, 1.2.1, ЗГҮАХ-2.6.4	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II", "Монгол соёл, Монголын баялаг" цогц арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	50.0	-	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нөхцөл бүрдээгүй.	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.	Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үнэлгээ төлөвлөлтийн арга зүйг сайжруулах, сумдыг бүсчилсэн үйлдвэрлэлд чиглүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж тодорхойлох зорилгоор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн онол практикийн асуудал сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Мөн Соёл урлагийн Их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд СУИС-ийн Соёлын үйлдвэрлэлийн тэнхимийн эрхлэгч Б.Эрхэмтөгстэй хамтран "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" танхимын сургалт, Бүтээлч үйлдвэрлэлийн төлөвлөлтийн арга зүй цахим сургалтыг тус тус зохион байгуулж соёлын салбарын албан хаагчид бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 21 иргэнийг хамруулсан. Түүнчлэн "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестиваль, "ITM 2022" "Айрагны баяр" гэх мэт улс аймгийн томоохон Тудаагийн үзэсгэлэн болон наадмуудад соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн 80 хувьтай хэрэгжсэнээр Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид Соёлын байгууллагуудтайгаа уялдаа холбоогоо сайжруулж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтын орлого нэмэгдэж үйлдвэрлэл эрхлэх өргөн боломж нээгдэж байна.	90	
2.5.6	ЗДМХ-1.4.2	Соёлын төвүүдийн барилгыг үе шаттай засварлах, шинэчлэх	1,113.6	797.0	-	Бугат сумын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, Сэлэнгэ сумын соёлын төвийн засварыг эхлүүлсэн байна.	2022 онд Бугат сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгыг 1.7 тэрбум төгрөгийн өртөөр барьж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 30.0 хувьтай явагдаж байна. Сэлэнгэ сумын соёлын төвийн дэвэрийн засварыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хурмастын хүлэг" ХХК хийж гүйцэтгэлээ.	90	
Бүлэг 3. Эдийн засгийн бодлого									
Зорилго 3.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай орчныг бүрдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгоно.									
3.1.1	ЗДҮАХ 2.1.3.1	Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлтийг дотоодын худалдан авалтаар дэмжих	-	-	1.7 тэрбум төгрөгийн дотоод худалдан авалт хийсэн.	Суурь төвшинөөс бууруулахгүй байна.	Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 13.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 77 төсөл арга хэмжээнээс 10 дугаар сарын 31-ний байдлаар 68 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл шалгарч 10.7 тэрбум төгрөгийн гэрээг байгуулж ажилласан. Үүнээс 24 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 3.7 тэрбум төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэсэн байна.	70	
3.1.2	ЗДҮАХ 2.3.1.1	Бизнесийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэн "Нэг сум-Нэг брэнд бүтээгдэхүүн" аян зохион байгуулах	15.0	-	-	ЖДҮ эрхлэгчдийн ур чадвар, бүтээгдэхүүний чанар сайжирсан байна.	Орон нутгийн онцлог нэрийн бүтээгдэхүүнийг энгийнээс органик руу шилжүүлэх зорилгоор "Гурванборхууд" ХХК-ийн "Арвайн гурил", "Тунамал Өгөөж" ХХК-ийн цайны цуврал, "Сүргийн нуга" ХХК-ийн "Зөгийн бал" зэрэг 5 нэрийн бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүний шаардлагад нийцүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. "Их шүүдэргэнэ" цувралын түүхий эд тариалах газрыг Орхон суманд шийдвэрлэж, органик цэвэр түүхий эдийг бэлтгэхэд бодит дэмжлэг үзүүлээ. "Нэг сум-Нэг брэнд бүтээгдэхүүн" аяны хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дижитал шилжилтэд бэлтгэх, бус нутгийн онцлог чанартай бүтээгдэхүүний нэр хүндийг илтгэх тэмдэг "Газар зүйн заалтын үндсэн ойлголт, ач холбогдол" сэдэвт сургалтад холбогдох сум, байгууллагын мэргэжилтнийг хамруулав. Сайхан сумын айраг үндэсний хэмжээнд газар зүйн заалтаар баталгаажсан бөгөөд цаашид аймгийнхаа Орхон голын сав дагуу нутагт сайхан айраг исгэдэг сумдыг хамруулан айрагны газар зүйн заалтыг өргөтгөж, тэлэх тухай Оюуны өмчийн газартай санал солилцоо. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж иргэдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 9 аж ахуйн нэгжийн 22 бүтээгдэхүүн тохирлын үнэлгээний шаардлагад нийцэж, баталгаажсан. Хангинахын шугуйн шагайн тойром, Айраг наадам, Айраг DAY, ITM өвөнт арга хэмжээнүүдэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон 325 аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан 1.0 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийж, сурталчилж ажилласан байна. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, хүнс үйлдвэрлэгчдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.	90	

3.1.3	ЗДҮАХ 2.3.1.2	Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлж, иргэдийн тогтвортой чанартай үйлчилгээ авах нөхцөл бүрдүүлэх	342.0	760.8	9 сум ахуйн үйлчилгээний төвтэй.	Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний төвийг засварлах Могод сумын халуун усны барилга Булган суманд оёдлын цехийг ашиглалтад оруулна.	"Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийн 76.0 сая төгрөгийн хөрөнгөөр оёдлын үйлдвэрийн 20 тоног төхөөрөмж, 26 дагалдах хэрэгслийг авч, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Булган аймгийн хамтын ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 299.8 сая төгрөгөөр оёдлын үйлдвэрийн байртай болж, үйлдвэрлэл явуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Гурванбулаг суманд орон нутгийн хөгжлийн сангийн 200.0 сая төгрөгөөр ахуйн үйлчилгээний барилгын засварын ажлыг "Банхүү" ХХК, Могод сумын халуун усны барилгын гүйцэтгэгчээр "Хүрэн жинсний овоо" ХХК шалгарч барилгын ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулав. Ахуйн үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж, салбарын ажиллагсдыг шагнаж урамшууллаа. Булган сумын 6 дугаар баг Чин ван Ханддоржийн өргөн чөлөө 1-р гудамж 109а тоотод Бизнес хөгжлийн төв буюу ахуйн үйлчилгээний төв барих 654 м.кв газрыг шийдвэрлэж, зураг төслийг "Аслаан" ХХК 40.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байна.	90	
3.1.4	ЗДҮАХ 2.3.1.3	"Сум хөгжүүлэх сан"-ийн чанаргүй зээлийг бууруулж, зээл олгох нөхцөлийг сайжруулах	3.0	876.0	11 сум 138 төсөлд 957.5 сая төгрөгийн зээл олгосон.	Чанаргүй зээлийг 5-аас доошгүй хувь бууруулна.	Аймгийн "Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэл", сумын тухайн жилд дэмжин хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд Хоршоо хөгжүүлэх сангаас 29 бизнес төсөлд 876.0 сая төгрөгийн зээл олгогдож, зээл олголт үргэлжилж байна. Нийт 137 төсөлд 2.0 тэрбум төгрөгийн зээл олгогдоносоо чанаргүй муу зээлийн ангиллын зээлгүй болж, 12 төслийн 119.5 сая төгрөгийн эргэлзээтэй зээлтэй байна.	100	
3.1.5	ЗДҮАХ 2.3.2	Бизнес эрхлэгчдийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан болон гадаадын төсөл хөтөлбөрийн дэмжлэгт хамруулах	-	160.0	Батлан даалтын сангаас 1 төсөл 500.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан.	Зээлийг зориулалтын дагуу 100 хувь зарцуулсан байна.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сангаас 2 төсөл 160.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдлаа. "Хөдөө аж ахуйг дэмжих" болон "Ажлын байрыг дэмжих" 3.0 хувийн хүтээг зээлийн төслүүд амжилттай хэрэгжиж байна. ЖАЙКА /JICA-ын санхүүжилттэй "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II" төслийн 6.0 хувийн хүтээг 10 жилийн хугацаатай зээлийн мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын цахим хуудас, "Сайхан Монгол" ТВ болон сумын мэргэжилтнүүдээр дамжуулан аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргүүлсэн. Зээлийн батлан даалтын сангийн мэдээллийг "Хүнсний хувьсгал" нээлтийн арга хэмжээний үеэр 100 гаруй иргэн болон 16 суманд цахимаар өгөв. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас үр тарианы 26 аж ахуйн нэгж, иргэнд 2264.3 сая төгрөгийн, хүнсний ногоо тариалагч 37 аж ахуйн нэгж, иргэнд 733.8 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн.	90	
3.1.6	ЗДҮАХ-2.3.4	Булган суманд стандартын шаардлагад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудал шинээр барьж ашиглалтад оруулах	5,000.0	1,100.0	Барилга бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.	Барилгын ажлыг гүйцээж ашиглалтад оруулсан байна.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/162 дугаар захирамжаар "Супрема бүтик лоджес" ХХК-нд 10814 м.кв газрыг зочид буудлын зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ 64.8 сая төгрөгийг төлүүлэн газар эзэмших гэрээ, гэрчилгээг олгосон. Зочид буудлын барилгын ажил 68.0 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70	
3.1.7	ЗДҮАХ-2.3.6	Хүн амын хаврын хэрэгцээний махыг нөөцлөн бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах	320.0	20.3	2019 онд 16.0 тн мах нөөцлөн бэлтгэж, аймгийн төвийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн.	40 тн-оос багагүй мах нөөцлөнө.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/147 дугаар захирамжаар "Мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх, түүнийг хадгалах, худалдан борлуулахад хяналт тавих" гэрээг Булган сумын "Өнө мөнх бадрах" ХХК-тай байгуулж, гэрээний хүрээнд 1 кг үхрийн махыг 10500, хонины махыг 8500, ямааны махыг 8000 төгрөгөөр борлуулж, кг тутамд 2000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэж, 10.2 тн мах бэлтгэн нийлүүлж, 20.3 сая төгрөгийн урамшуулал олголоо. Аймгийн хэмжээнд 2021-2022 оны өвөл, хаврын хэрэгцээнд 9 аж ахуйн нэгж, иргэн 61.5 тн мах нөөцлөн бэлтгэж нийлүүлэв. "Хутаг-Өндөр мах маркет" ХХК нь улсын нөөцөд 250.0 тн мах бэлтгэн нийлүүлсэн. Хангал суманд "Халганат эю мах" ХХК нь хоногт 50 бод, 200 бод мал нядлах хүчин чадалтай, 50 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулах бүхий үйлдвэр ашиглалтад оруулж, үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв.	100	
3.1.8	ЗДҮАХ-2.3.6	Орон нутагт сүүний үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хангамжийг нэмэгдүүлэх	1,500.0	612.2	Аймгийн төвд 400 тн сүү үйлдвэрийн аргаар боловсруулсан, 5 суманд сүүний хөргөлтийн цэц байгуулагдсан.	Тэшиг суманд Цөцгийн тос үйлдвэрлэх ажиллагааг байгуулах ажлыг эхлүүлсэн байна.	Шинэ хөдөө төслөөс Бугат, Булган, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд 263.2 сая төгрөгийн өртөг бүхий 7 ширхэг сүү хөргөх танк нийлүүлснийг Булган сумын "Хатан мээж хайрхан" ХХК-д түрээслүүлж, малчид 450 тн сүү нийлүүлж, 315.0 сая төгрөгийн орлого олж байна. Түрээслэгч талаас танкуудыг ашиглалтад оруулахад 31.5 сая төгрөг зарцуулсан. "Хатан Мээж хайрхан" ХХК гэрээт аж ахуйн нэгжүүдэд 34.0 тн цөцгийн тос, 9.5 тн аарцыг нийлүүлэв. Тэшиг суманд 250 толгой үхрийн ферм, хоногт 6 тн сүү боловсруулах хүчин чадалтай цөцгийн тосны үйлдвэр байгуулах газрыг сумын ИТХ-аар шийдвэрлэж, энэ онд улсын төсвийн 300.0 сая төгрөгөөр ТЭЗҮ хийгдэж, үйлдвэрийн шавийг тавиад байна. Булган сумын "Эю хүнс" ХХК-ийн "Чихэртэй ааруул", "Чихэртэй ааруул" нарийн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулан баталгаажуулж, Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв ямааны 40 кг ааруул үйлдвэрлэжээ. Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/478 дугаар тушаалаар "Хатан мээж хайрхан" ХХК бэлтгэн нийлүүлэгчээс түүхий сүү хүлээн авах шаардлага хангаж, энэ жилийн сүүний урамшуулалд хамрагдах эрх авч 10 тн шингэн сүү өвлийн улиралд авах, гэрээ хийгдсэн.	100	
3.1.9	ЗДҮАХ-2.3.6	Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж, хөгжүүлэх	500.0	-	Булган сумын шахмал түлшний үйлдвэр хүчин чадлын 10%-ыг ашиглаж, Сэлэнгэ сум, Хялганат тосгоны үйлдвэр ажиллаагүй.	Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	Сайхан сумын Эрэний нүүрсний ордыг түшиглэж, орон нутгийн төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилд 10000 тоннын хүчин чадалтай сайжруулсан түлшний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсны дараа үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	30	
3.1.10	ЗДҮАХ-5.1.1	Булган, Орхон суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, бүтээн байгуулах	500.0	-	Аймгийн төвд бетон зуурмагийн үйлдвэр байгуулагдаж, тоног төхөөрөмж угсралтын ажил хийгдэж байна.	Булган суманд бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад оруулна.	Булган сумын 1-р баг Байгаль орчин-4 гудамж 410 тоот байршилтай газарт "Дэвших бетон" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад орж, 540 тн зуурмаг орон нутгийн барилга бүтээн байгуулалтад нийлүүлсэн байна. Цементийн хомсдол, үнийн өсөлтөөс шалтгаалж бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байна.	100	
3.1.11	ЗДҮАХ-5.1.2	"Булган үйлдвэр технологийн төв", д гадаад дотоодын хөрөнгө оруулалт татаж, эхний ээлжинд 1100 тн ноос угаах үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагчийг бодлогоор дэмжих	1,000.0	-	Үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдсан, бүсэд "Бүрэн луу" ХХК ТХХТ хүрээнд мал нядлах үйлдвэрт өргөтгөл хийж, дэд бүтцийг шийдвэрлэсэн.	Мах боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлнэ.	Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөнд манай аймагт махны агро парк байгуулахаар тусгагдаж, Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсгэл 91302 м.кв талбай бүхий газрыг Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлэх шийдвэрийг гарган цахимаар газрын гэрээ байгуулан, БНХАУ-ын 19.5 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор" баригдах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.	50	
3.1.12	ЗДҮАХ-5.1.2	Орхон суманд түүхий эдийн захын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх	1,000.0	200.0	ХАА-н түүхий эд борлуулах нэгдсэн зах байхгүй.	Инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлнэ.	Түүхий эдийн захын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг хэрэгжүүлэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар 2022 онд 200 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, "Булгангэрэгэ" ХХК тендэрт шалгарч гэрээ байгуулаад байна.	70	

Зорилго 3.2. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.										
3.2.1	МУТЖУЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5	Ойжуулалт, нөхөн сэргээлт, ойн хортны тэмцлийн ажлыг хэрэгжүүлэх	298.5	326.2	Ойжуулалт /200 га/ Бугат, Бүрэгхангай, Сэлэнгэ, Орхон, Хангал, Хишиг-Өндөр	Ойжуулалт /50га/ /Бугат, Бүрэгхангай, Сэлэнгэ, Орхон/	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 3 багц ойжуулалтын ажил, 2 багц байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэх тендер зарлаж 1, 2 дугаар багцын Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ сумын 35 га талбайд бортоготой тарьцаар ойжуулалт хийх ажилд Орхон аймгийн "Хөвөнтөн ой" ХХК шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/242, А/386 дугаар захирамжаар гэрээ байгуулан тарилтын ажлыг гүйцэтгэж, намар амьдралтын 71.5 82.0 хувьтай аймгийн комисст хүлээлгэж өгөв. Бугат, Сэлэнгэ суманд суулгацаар хийгдэх 3 дугаар багцад Булган сумын "Тайгын үндэс" ХХК шалгарч, аймгийн Засаг даргын 2022 оны А/607 дугаар захирамжаар гэрээ байгуулан намрын тарилтыг хийж гүйцэтгэлээ. Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын 2 дугаар багцад Завхан аймгийн "Ургах нахиа" ХХК шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/387 дугаар захирамжаар гэрээ байгуулан шат, 40х40 талбайн хөрсийг хуулан үр болон тарьцаар байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, амьдралтын явц 70.0-76.0 хувьтай хүлээлгэн өгсөн. Мөн энэ онд мод бэлтгэлийн аж ахуйн нэгжүүд 47.4 га талбайд ойжуулалтын ажлыг хийсэн. Дээрх ажлуудын дүнд аймгийн хэмжээнд 103 га талбайд ойжуулалт, 50 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэв.	100		
3.2.2			21.0	21.0	Ойн хортны судалгааны ажил 300000 га-д хийсэн.	Ойн хортны судалгааны ажил /300000га/	Ойн хортны судалгааны ажлыг аймгийн Засаг даргын 2022 оны А/474 дүгээр захирамжаар 21.0 сая төгрөгөөр "Мөнх ногоон ой" ХХК-тай гэрээ байгуулан 311000 га талбайд гүйцэтгүүлж, 2023 онд тэмцэл явуулах талбайн судалгааг гаргав.	100		
3.2.3			383.0	382.9	Ойн хортны тэмцлийн ажлыг 30800 га /Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Баян-Агт, Бугат, Орхон, Бүрэгхангай, Сэлэнгэ/	Ойн хортны тэмцлийн ажил Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Баян-Агт, Бугат, Орхон, Сэлэнгэ /28000 га/	Ойн хортны тэмцлийн ажлын тендерийг 2 удаа зарлаж "Гранд форест" ХХК, "Ойн таксаци" ХХК-иуд шалгарч аймгийн Засаг даргын А/368 тоот захирамжаар гэрээ байгуулан Бугат, Хангал, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт, Орхон сумдад 12000 га талбайд тэмцлийн ажлыг 382900.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.	100		
3.2.4	ЗДМХ-3.2.1	Ой бүхий зарим сумдад "Хожуул" төслийг хэрэгжүүлэх	60.0	60.0	Бүрэгхангай суманд "Хожуул" төслийг хэрэгжүүлж эхэлсэн.	Бүрэгхангай, Бугат, Орхон, Баян-Агт суманд төсөл хэрэгжүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/160 дугаар захирамжаар Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон суманд "Хожуул" төслийг хэрэгжүүлэв. Бүрэгхангай сум "Дархан уул" 12.3 га, "Ар цуурай" 6 га, "Халзангийн даваа" 49.4 га, "Хуст бэлчир" 27.4 га, "Баянхангай" 4 га нийт 100 га талбайн 220000 ширхэг хожуулаас 2719.4 м.куб мод, Орхон сумын 1-р баг "Баруун могойн Бургаастад" 24.5 га талбайд тусгаарлалт хийлгэж, 4000 хожуулаас 180 м.куб, Баян-Агт сум "Цийлэн", "Мод даваа", "Сүжийн даваа" зэрэг газарт 8 га талбайд тусгаарлалт хийж, 960 ширхэг хожуул цэвэрлэн 61 м.куб, Бугат сум "Ханжаргалант" багийн нутаг "18-тйн дөрөлж", "100 мод", "Нартын хавтайд" 40 га талбай тусгаарлаж, 40000 ширхэг хожуулаас 800 м.куб түлшний мод бэлтгэсэн. Уг төслийн хүрээнд нийт 3760.4 м.куб модыг сум орон нутгийн иргэдийн түлшний хэрэгцээнд нийлүүллээ.	100		
3.2.5	МУТЖУЧ-6.4.6, 9.2.2, ЗГҮАХ-5.1.9	Аюултай хог хаягдлыг түр хадгалах байр барих	300.0	-	Газрын асуудлыг шийдсэн.	Аюултай хог хаягдлыг түр хадгалах байр баригдана.	2021 онд улсын төсвийн хөрөнгөөр Архангай, Өвөрхангай, Булган аймагт Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын барилга барих нээлттэй тендерийг БОАЖЯ-наас зарлаж, гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын "Жам" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус компани нь 2022 онд аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын барилгын зураг төсвийг хийлгэн хянан магадлуулж, 6-р сард ажлаа эхэлсэн. Агуулахын барилгын ажил одоогийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй баригдаж, энэ онд багтаан хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.	70		
3.2.6	ЗДМХ-3.1.5	Сумдад хог хаягдлыг тээвэрлэх машин тоног төхөөрөмж нийлүүлэх	650.0	650.0	Булган суманд 1 автомашин олгосон.	9-өөс доошгүй суманд хог хаягдал тээвэрлэх автомашин олгоно.	2022 онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалт 450 сая төгрөгөөр Булган, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчилэн 6 суманд хог ачих зориулалтын тоноглогдсон авто машин, Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 200 сая төгрөгөөр хог ачих зориулалтаар 4 автомашин Баян-Агт, Гурванбулаг, Тэшиг сум, Хялганат тосгонд нийлүүлэхээр төслийг аймгийн ИТХ-аар батлуулсан. Нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Цаст хан хөхий" ХХК шалгаран гэрээ байгуулсан. Автомашинуудыг Хятад улсын Эрээн хотын хилийн боомт дээр авчирсан боловч хил гааль хаасантай холбогдуулан гэрээний хугацааг 10-р сарын 20-ны дотор нийлүүлэхээр сунгасан боловч хилээр нэвтрэх дугаарыг хүлээж байгаа учраас дахин гэрээний хугацааг сунгасан.	90		
3.2.7	МУТЖУЧ-2.5.3, ЗГҮАХ-5.1.4	Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх	210.0	168.8	2020-2021 онд 200 айл өрхийг стандартын шаардлагад нийцсэн соруулдаг жорлонтой болгосон.	100 айл өрхийг стандартын шаардлагад нийцсэн жорлонтой болгоно	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Булган сумын гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонд хийгдэх ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын нээлттэй тендер Орхон аймгийн "Цэцэн шунхлай" ХХК гүйцэтгэгчээр шалгаран Булган сумын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн газрын 2715 нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Булган сумын нийтийн эзэмшлийн 9 байршилд 18 соруулдаг жорлон барих ажлыг 73.0 сая төгрөгөөр "Булган Мээж" ТӨХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.	100		
3.2.8	МУТЖУЧ-6.2.1, 6.2.4, ЗГҮАХ-5.1.5	Цөлжилтийг сааруулах, элсний нүүллээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	90.0	90.0	Рашаант сумын Элсэн тасархайд 2 га газарт элсний нүүллээс хамгаалах зурвасын ажлыг хийж гүйцэтгэсэн.	Дашинчилэн, Рашаант, Хутаг-Өндөр суманд нийт 5 га-д хийнэ.	Дашинчилэн, Рашаант суманд элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлын тендер Дашинчилэн суманд "Хөвөнтөн ой" ХХК шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/336 дугаар захирамжаар гэрээ байгуулж 2.5 га талбайд 3000 ширхэг мод тарьснаас 2236 ширхэг мод ургах, нөхөн тарилт хийлгэж амьдралтын 90.7 хувьтай аймгийн комисс хүлээн авсан. Рашаант сумын Элсэн тасархайд "Газарзүй, геоэкологийн хүрээлэн" шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/606 дугаар захирамжаар гэрээ байгуулан хашаа хамгаалалт, тарилтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэлээ.	100		
3.2.9	ЗДМХ-3.1.1	Булаг шанд, Ачуут, Далын голын эхийг хашиж хамгаалах	68.0	68.0	10 суманд булаг шандын эхийг хашиж хамгаалсан.	Далын гол болон 10 суманд булгийн эхийг хашина.	Аймгийн ИТХ-ын хуралдааны IX/16 дугаар тогтоолоор 68.0 сая төгрөгийг батлуулсан Баян-Агт, Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Хишиг-Өндөр суманд 10 булаг шандын эхийг хашиж хамгаалах тендерийн ажлыг 3 удаа зарласан боловч бараа материалын өсөлттэй холбоотой гүйцэтгэгчээр компани ороогүй тул шинээр усны эх үүсвэрийн хамгаалалтын хашааны зураг төсөл боловсруулан дахин тендер сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна.	30		

Зорилго 3.3. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.3.1	ЗГҮАХ-3.4.4	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, дотоодын болон гадаадын аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх	40.0		Булган, Хутаг-Өндөр суманд 2 байршилд отоглох цэгийг барьж байгуулсан.	Булган, Хутаг-Өндөр суманд байгуулсан отоглох цэгийг нэмж тохижуулан, 1 отоглох цэгийг шинээр байгуулна.	2021 онд Хутаг-Өндөр сумын Дондогийн булаг улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгөөр түр буудаллах цэгийг "Сүвдан элс" ХХК барьж, 2022 оны 5 сард гүйцэтгэгч компани хүлээлгэн өглөө. Мөн 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр Рашаант сумын элсэн тасархай "Өвөлжөөн булаг" ХХК, Баян-Агт сумын Хануй рашаанд "Сонхот" ХХК отоглох цэг байгуулах ажлыг 100 хувь гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Булган, Хутаг-Өндөр сумдад аялагчдын тав тухыг хангах зорилгоор отоглох цэгийн тохижилтыг нэмж хийлгэхээр сумдад тус бүр 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгож Булган сумын отоглох цэгийг тойруулан хайс, гэрэлтүүлэг, шорлог хийх цэг, 50 ширхэг шар хайс, хүүхдийн тоглоомын талбай, бие засах газар, орчны өнгө зүсийг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.	100	
3.3.2	ЗГҮАХ-3.4.8	Аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг идэвхжүүлэх, аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ бий болгох	125.0	84.2	Суурь судалгааны ажил хийж, дижитал платформ бий болгох ажлыг 2021 онд эхлүүлсэн.	2022 оныг "Аялал жуулчлалын жил" болгон зарлаж, хэрэгжүүлэх, Дижитал платформ бий болгоно.	Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн, рашаан сувиллын, түүх соёлын контент хийхэд 40.0 сая төгрөгийг зарцуулан 3 төрлийн 7 контент, видео бичлэг хийв. Мөн аймгийн аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ, хөгжүүлэх зорилго бүхий "visitbulgan.mn" веб сайтыг 45.0 сая төгрөгөөр хийлгүүлэхээр тендер сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрууд болон музейн үзмэрүүдийн виртуал танилцуулгыг "Дижитал сольшн" ХХК 24.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, жуулчид, аялагчдад зориулсан газрын зураг, танилцуулгыг шинэчлэн гаргах ажлын гүйцэтгэгчээр "МРМ" ХХК шалгарч, 14.7 сая төгрөгөөр англи, монгол хэлээр 6500 ширхэгийг хэвлэн гүйцэтгээд байна.	90	
3.3.3	ЗДМХ-3.2.1	Аймгийн бренд бүтээгдэхүүний өргөө барих	1,000.0	240.0	-	Хутаг-Өндөр суманд барилгын ажлыг эхлүүлнэ.	Улсын төсвийн 240 сая төгрөгийн хөрөнгөөр Хутаг-Өндөр сумын Дондогийн булаг "ДИБИТИБИ" ХХК нь Бренд бүтээгдэхүүний 2 өргөө барих ажлыг гүйцэтгэж байна.	100	
Зорилго 3.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэргэцгээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.									
3.4.1	МУТЖҮЧ-8.3.6, 8.3.11, ЗГҮАХ-3.3.1, ЗДМХ-2.2.5	Энгийн болон инженерийн хийц бүхий усралтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	185.0	534.0	Өнгөрсөн 4 жилд инженерийн хийцтэй 83 худаг гаргасан.	10 худаг гаргана.	2022 онд улсын төсвийн 178.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Могод суманд тус бүр 1 худаг шинээр гаргах тендерийн дагуу "Булган-Ус" ХХК 4 худаг гаргах хүлээлгэн өгсөн. Мөн орон нутгийн төсвийн 185.0 сая төгрөгийн хөрөнгөөр Булган, Бүрхэнгай, Дашинчилэн, Могод, Орхон, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд цуснаар 10 худаг, Бугат, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр суманд 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 худаг, малчид 24.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 худаг, нийт 30 худаг гаргаад байна.	100	
3.4.2	БАХҮЧ 2.3.3, ЗДМХ-2.2.4	Малын тэжээлийн үйлдвэр байгуулж, 1000-аас доошгүй тн тэжээл бэлтгэх	50.0	-	Тэшиг, Хутаг-Өндөр, Орхон суманд тус тус 1 малын тэжээлийн үйлдвэр байна.	Хишиг-Өндөр суманд малын тэжээлийн үйлдвэр байгуулна.	Хишиг-Өндөр сумын "Дархан хаан Молор" ХХК малын тэжээлийн үйлдвэр байгуулж, 98 га талбайд тариалалт хийж, 48 тн тэжээл хураан авлаа.	100	
3.4.3	ЗДМХ-2.2.6	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулж, өвчин гарах, тархах нөхцөлийг хязгаарлах	607.6	607.6	Нийт өвчлөлийн 2 хувь	1.8 хувь хүртэл бууруулна.	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвийн 607.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1488.1 мянган толгой мал, амьтан хамруулахаас 1398.8 мянган толгой мал, амьтан хамруулж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Аймгийн хэмжээнд мал, амьтны шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтй дархлаажуулалтад 9211 өрхийн 362.0 мянган толгой мал, амьтан хамруулахаас 4181 өрхийн 343.9 мянган толгой мал, амьтан хамруулж, 95.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлээд байна.	70	
3.4.4	ЗДМХ-2.2.5	Хадлангийн талбайг сэргээх "Бор булан" төслийг хэрэгжүүлэх	1,500.0	300.0	-	Хадлангийн талбайг хашиж хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.	Бор булангийн хадлангийн талбайг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер Төрийн худалдан авах ажиллагааны газарт зарлагдсан.	30	
Зорилго 3.5. Дэд бүтцийн төлөвлөлт, төв суурингийн хөгжил. Аймгийн дэд бүтцийн салбарын хөгжүүлж, иргэд яа тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.									
3.5.1	БАХҮЧ 4.1.1, ЗДМХ 3.4.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах	500.0	500.0	2017 онд хийгдсэн аймгийн ГЗБЕТ хэрэгжээд дууссан.	Аймгийн ГЗБЕТ ИТХ-аар батлуулсан байна.	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу "Вектор мэн" ХХК 2019-2021 оны хооронд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын IX Хуралдаанд хэлэлцүүлж, 2022 оны IX/18 дугаар тогтоолоор баталгаажуулан газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	
3.5.2	БАХҮЧ 4.1.1, ЗДМХ 3.4.1	Бугат, Рашаант сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох ажлыг эхлүүлэх	120.0	59.4	14 сум, 1 тосгон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй.	2 сумыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгосон байна.	Булган аймгийн Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар ЕТ-01/2022, Бугат сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ЕТ-02/2022 дугаартай зургийн даалгаврыг тус тус боловсруулж, Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газарт хянуулан, Бугат сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгчээр "Эрхэт констракшн" ХХК шалгарч, зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээд байна.	50	
3.5.3	МУТЖҮЧ-2.39, ЗГҮАХ-3.7.3, ЗДМХ-3.4.3	Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй барилгуудад үнэлгээ хийж паспортжуулалтын ажлыг эхлүүлэх	50.0	50.0	Барилгын гаргасан.	судалгааг бүх барилдаг дүгнэлт гаргана.	Орон нутгийн 2022 оны төсөвт 50.0 сая төгрөг тусган Булган сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дадлагын байр, Эрдмийн Өргөө цогцолбор сургуулийн хичээлийн байрны 1-р блок, Сайхан сумын сургуулийн хичээлийн байр, Бугат сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Хялганат тосгоны Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Захирагчийн ажлын албаны барилга, Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байр, Могод сумын Соёлын төв гэсэн 9 барилгыг паспортжуулахаар даалгавар боловсруулсан. Гүйцэтгэгчээр шалгарсан "Бүүвэй цагаан барс" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хяналт тавин ажиллаж байна.	90	
3.5.4	ЗДМХ-3.4.3	Барилгын засвар, дулаалгын ажлын эрэмбийг тогтоож, ээлж дараатайгаар хэрэгжүүлэх	200.0	702.0	Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа төсвийн байгууллагын нэгдсэн судалгаа хийгдсэн.	5 барилга дулаална.	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 12, 14, 15, орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18а, 18б байрны барилгын гадна ханын засварын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулав. Мөн орон нутгийн төсвийн 342.0 сая төгрөгөөр аймгийн төвийн 16 байрны 40 орчны өнгө засал, хаалга шинээр хийх ажлыг "Өвөлжөөн булаг" ХХК гүйцэтгэж, гэрээний дагуу ашиглалтад оруулаад байна.	100	
3.5.5	ЗДМХ-3.4.4	"Сайн хашаа" төслийг сумын төв бүрд боловсруулж, хэрэгжилтийг үе шаттайгаар хангаж эхлэх	-	-	-	Суурь судалгаа хийгдсэн.	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн ажил дуусаж, шат шатны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэн аймгийн ИТХ-ын 2022.03.29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор батлуулж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөлийн хурал болон магадлалаар хянуулж, хот төлөвлөлтийн нэгдсэн системд оруулсан. Булган сумын Засаг даргын Тамгын газартай хамтран "Сайн хашаа", "Удамж" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, төслийг хэрэгжүүлэх ажлын зураг төсвийн даалгаврыг боловсруулж байна. Хөдөө сумын төв бүрд сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан "Сайн хашаа" төслийг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажлын даалгаврыг боловсруулсан.	50	

3.5.6	ЗДМХ-3.4.5	Төв суурин газруудын ногоон байгууламжийг 30 хувиар нэмэгдүүлэх	100.0	628.6	Аймгийн хэмжээнд 26000 м2 талбай ногоон байгууламжтай.	Ногоон байгууламж хийгдсэн байна.	Төв суурингийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 1.5 км газарт 12 нэр төрлийн 8 өнгийн 12600 ширхэг цэцгийн үрсэлгээг хийж арчлан 100% ургуулсан. Булган сумын 18-р байрны орчим 300 м2 талбайд шинээр хамгаалалтын торон хайсыг хийн зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. Мөн хуучин зүлэгжүүлсэн талбайн халцарсан 100 м2 талбайд нөхөн тарилт хийж арчилсан. Аймгийн хэмжээнд "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1513 өрх 26692 ширхэг мод тарьж, ногоон байгууламжинд 461 аж ахуй нэгжийн 133687 ширхэг мод, 52300 м2 талбайг хашин хамгаалж зүлэгжүүлэн мод тарьж, 628662.5 мянган төгрөг зарцуулан ногоон байгууламжийг 15 хувиар нэмэгдүүлээ.	100	
3.5.7	ЗДМХ-3.4.6	Булган сумын гэр хорооллын гудамж талбайг үе шаттайгаар гэрэлтүүлэгтэй болгох	300.0	380.0	Гэр хорооллын гудамж талбайн 5 хувь нь гэрэлтүүлэгтэй.	1,4,6 дугаар багийн гудамж талбайг гэрэлтүүлэгтэй болгоно.	Булган сумын 1, 4, 6 дугаар багийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажлыг орон нутгийн төсвийн 380 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Сервис по сименс" ХХК шалгарсан, угсралтын ажил дуусаж ашиглалтад оруулаад байна.	100	
3.5.8	БАХҮЧ-4.1.2, ЗДМ-3.4.8	Булган суманд барилгажсан хэсэгт хэрэглээний халуун усны хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх	350.0	698.0	2021 оны ОНТ зураг төсөв хийлгэх, зарим орон сууцны холбохоор 350,0 сая төгрөг тусгасан.	Орон сууцны барилгуудыг халуун устай болгоно.	Булган сумын айл өрх аж ахуйн нэгжийг үе шаттайгаар хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын хүрээнд 2 болон 5 дугаар УДДТ-ийн үйлчилгээний хүрээний нийтийн орон сууц төр төсвийн байгууллагын хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын зураг төслийг "Онолт од" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2021 онд Аймгийн орон нутгийн төсвийн 348 сая төгрөгөөр "Нью гранд пропर्टийз" ХХК гэрээ байгуулан 1 ба 6 дугаар цэцэрлэг, 18а, 18б байрны хэрэгцээний халуун усны шугамын угсралтын ажлыг гүйцэтгэж 2022 оны 05 сарын 16-ны өдөр ашиглалтад хүлээлгэж өгсөн. 2022 онд 2 дугаар шатны ажил дээр аймгийн орон нутгийн төсвийн 350 сая төгрөгөөр 14, 15, 22, 23 дугаар нийтийн орон сууцны холбохоор төндөр зарлаж "Сувдан элс" ХХК шалгаран аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэж ашиглалтад оруулаад.	100	
3.5.9	БАХҮЧ-4.2.1, ЗДМХ-3.4.9	Сайхан сумын төвийн 1.7 км хатуу хучилттай авто зам барих	533.6	-	1,7 км шороон замтай, 2021 оны улсын төсөвт 0,8 км зам барих 500,0 сая төгрөг батлагдсан.	0,8 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлсэн байна.	Хөрөнгө оруулалт татагдсан	0	Хөрөнгө оруулалт татагдсан
3.5.10	БАХҮЧ-4.2.1, ЗДМХ-3.4.9	Сумын төвүүдийг ээлж дараатайгаар хатуу хучилттай авто замтай болгох	1,080.0	280.0	4 сумын зураг төсөл нь хийгдсэн.	Дашинчилэн, Орхон, Бугат сумын төвд авто зам барина.	Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын төвд 2.2 км хатуу хучилттай авто замын ажлыг 140 сая төгрөгт багтаан гүйцэтгэхээр "Булган АЗЗА" ТӨХК шалгаран ажлыг эхлүүлээд байна. Мөн Орхон сумын төвийн 2.8 км хатуу хучилттай авто замын ажлыг 140 сая төгрөгт багтаан гүйцэтгэхээр "Булган АЗЗА" ТӨХК шалгаран ажлыг гүйцэтгэж байна.	100	
3.5.11	БАХҮЧ-4.2.1, ЗДМХ-3.4.10	Булган сумын төвд нийтийн эзэмшлийн авто зогсоолын талбай байгуулах	70.0	75.0	26002 м2 авто зогсоолтой.	960 м2 авто зогсоолын талбай байгуулна.	Булган сумын нийтийн эзэмшлийн авто зогсоолын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Булган сумын 5-р баг Өнө мандал дэлгүүрийн урд талд 865 м2 бетон авто зогсоолын талбай явган хүний замын гүйцэтгэгчээр "Ариун ган бумба" ХХК "Ариун ганга бумба" ХХК Булган сумын ЗДТГ-тай 75.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан 2022.05.01-ны өдрөөс 2022.06.15-ны өдөр хүртэл гүйцэтгэж Улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авсан.	100	
3.5.12	ЗДМХ-5.1.8	Тэшиг сумын төвд 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам тавих	1,000.0	200.0	Сумын төвийн цахилгааны хүчдэл муутай.	Гүйцэтгэгчийн сонгож, зураг төслийн дагуу ажлыг эхлүүлнэ.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төндөр зарлан "Смарткрафт" ХХК ажил гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулаад байна.	70	
3.5.13	ЗДМХ-5.1.8	Шинэ суурьшлийн бүсүүдийг ээлж дараатайгаар эрчим хүчний эх үүсвэртэй болгох	150.0	144.9	Гурванбулаг сумын шинэ суурьшлийн бүсийг цахилгаан эрчим хүчээр хангасан.	Хангал сумын Галтайн аманд 5 км ЦДАШ ашиглалтад оруулна.	Хангал сумын Галтайн аманд 5 км ЦДАШ татах ажлын гүйцэтгэгчээр "Гарьд системс" ХХК шалгарч сумын Засаг даргатай 2022 оны 04 дүгээр сард гэрээ байгуулж, 09 дүгээр сарын 05-ний өдөр улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан	100	
3.5.14	ЗДМХ 3.4.11	Бага оврын агаарын хөлгийн нислэгийг тогтмолжуулах	432.0	-	2020 онд туршилтын нислэг үйлдсэн.	7 хоногт 2 удаа нислэг үйлдэнэ. Жилд 96 удаа	2023 онд нислэг үйлдэх хүсэлтийг ЗГХЭГ, МХАҮТ-д илгээсэн	0	

Бүлэг 4. Засаглалын бодлого

Зорилго 4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

4.1.1	МУТЖҮЧ-7.4, ЗГҮАХ-4.1.1	Сумын улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжийг шинэчлэх	5.0	-	Хэрэгжилт 70 хувьтай байна.	Хэрэгжилт 85 хувьд хүрсэн байна.	Сумын улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд КОЙКА төслөөр компьютер, принтер, камер, хурууны хээ уншигч, иргэний үнэмлэх уншигч зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж ажилласан.	100	
4.1.2	ЗДМХ-4.2.6	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах	260.4	312.4	Зураг төслийг хийлгэсэн.	Аймгийн ЗДТГ-ын "Г" блокыг ашиглатад оруулсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Г блоккийг "Е-монголиа" төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад 247.6 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, 64.8 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан. Тус төвийг нээнээр төрийн үйлчилгээг иргэдэд дараалалгүй, түргэн шуурхай, үзүүлж эхэллээ.	100	

Зорилго 4.2. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

4.2.1		Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааг нэг жишигт стандартад хүргэхийн тулд лабораторийн барилга шинээр барьж, ашиглалтад оруулах	700.0	-	Төслийн хэрэгжилт 20 хувьтай байна.	Төслийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна.	Албаны байр шинээр барих байрны газрын асуудлыг Булган сумын 5-р багийн нутагт Нэгдсэн эмнэлгээс баруун тийш 300 метр газарт байршил сайтай, инженерийн шугамд холбогдох боломжтой газарт шийдвэрлүүлж, аймгийн Засаг даргын 2018.10.03-ны А/600 дугаар захирамжаар АЗДТГ-ын мэдэлд байсан газрыг албаны мэдэлд шилжүүлэн 725м2 газрын 00042911 дугаартай үл хөдлөхийн гэрчилгээ, 6308007394 нэгж талбарын дугаар бүхий кадастрын зураглалыг гаргуулж, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр 7 сая 250 мян.т-өөр үнэлүүлсэн. Дээрх газрыг 2022 онд алба хаагчдын хүчээр хашаажуулаад байна. Барилгын зураг төсөв, холбогдох материалыг дээд шатны байгууллагуудад уламжлан ажилласан.	30	
4.2.2	МУТЖҮЧ-7.4.3, ЗГҮАХ-4.3.7	Шүүхийн шинжилгээний албанд шинээр томилогдон ирж буй нөөц хомс, тусгай мэргэжлийн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, албаны мэдэлд 2 өрөө орон сууцтай болгох	60.0	60.0	Төслийн хэрэгжилт 20 хувьтай байна.	Төслийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна.	Тус албанд Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутгаас томилогдон ажиллаж байгаа криминаликийн шинжээч болон шинжээч эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулж 60 сая төгрөгийн өртөг бүхий албаны мэдлийн 2 өрөө 42 м2 байрыг худалдан авч Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаалаар тус албанд шинжээч эмчээр түр томилогдон ажиллаж байгаа алба хаагчдыг оруулаад байна.	100	
4.2.3		Химийн шинжилгээний лабораторид бодис урвалж хадгалах зориулалтын шүүгээ, ширээ, тавиур, техник хэрэгсэл бэлтгэх	4.4	-	Мэргэжилтнийг сургаж бэлтгэсэн, лабораторийг тохижуулсан, бодис урвалжийг бэлтгэсэн.	Төслийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна.	Саналыг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.	30	санхүүжилтгүй

4.2.4	МҮТЖҮЧ-7.4.1, ЗГҮАХ-4.3.2	Аймгийн 5 гүүрэн гарцны хяналтын камерын серверийг бүрэн шинэчлэх, Сэлэнгэ сумын гүүрэн гарцад шинээр хяналтын камер суурилуулах. Аймгийн төвд 6-р баг Залуус хотон, Хужир толгой, 4-р баг Зүүн түрүү, 1-р баг Балгас, Гандан чиглэлд шинээр хяналтын камер суурилуулах	42.3	50.0	Гүүрэн гарцны 5 цэгт камерын сервер шинэчлэх, 1 цэгт шинээр камер суурилуулсан.	Аймгийн төвд шинээр 55 цэг хяналтын камер суурилуулна.	Аймгийн төвийн хяналтын камерыг шинэчлэх, засвар үйлчилгээ хийхэд шаардагдах 50.0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 07 дугаар сарын ээлжит хуралдаанаар шийдвэрлэсэн. Тус санхүүжилтээр гудамж талбайд шинээр нэг чиглэлийн /bulle/ камер 20 ширхэг, эргэдэг /ptz/ камер 5 ширхэг, шилэн кабелийн мүүфт засвар үйлчилгээг хийлгэх, Зоон давааны зам тээврийн хяналтын постонд тээврийн хэрэгслийн дугаар бичигчтэй ANPR камер авахаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. Дээрх камеруудыг худалдан авч суурилуулснаар аймгийн төвд 33 байршилд 86 камер бүрэн ажиллах боломжтой болно.	70	
БҮЛЭГ ТАВ. БҮС НУТГИЙН БОДЛОГО									
Зорилго 5.1. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.									
5.1.1	ЗДМХ-5.1.3	Булган суманд 150 айлын орон сууц барих	1,000.0		2021 онд 28 айлын орон сууц баригдаж байна.	35-аас доошгүй айлын орон сууц ашиглалтад оруулна.	Булган сумын 5-р баг 186 байрны урд талд "Биг эко" ХХК-ны захиалгаар 2 блок 84 айлын орон сууцны барилгын эхний 1-р блокны суурийн ажил 2021 онд хийгдсэн. Булган сумын 5-р багт "Булган өргөө" хотхоны 2 дугаар блок 28 айлын орон сууцыг "Их азар" ХХК барьж 2022 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан. Нарлаг өргөө хотхоны баруун талд 25 айлын орон сууцыг Их-Ураг ХХК эхлүүлж, ажлын гүйцэтгэл 60%-тай явагдаж байна.	90	
5.1.2	ЗДМХ-5.1.3	Хутаг-Өндөр, Бугат, Хишиг-Өндөр, Могод, Баян-Агт, Сайхан, Орхон, Дашинчилэн, Бүрэгхангай, Рашаант, Гурванбулаг сумын төвд 128-аас доошгүй айл өрхийн орон сууц барих	430.0	140.0	Бүрэгхангай, Баяннуур суманд 2 орон сууцанд 22 айл айл байна.	4-өөс доошгүй суманд орон сууц барина.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Орхон сумдад нийтийн орон сууц барихаар төлөвлөгдсөн газруудад инженерийн шугам сүлжээ татахаар 1.5 тэрбум төгрөг тусгагдсан. Тус ажлын зураг төслийн зохиогчоор "Эрч булаг лайн" ХХК Орхон, Хутаг-Өндөр сумыг, "АСУ констракшн" ХХК Сэлэнгэ сумын шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер Төрийн худалдан авах ажиллагааны газарт зарлагдаж гүйцэтгэгчээр "Эрч арвин" ХХК шалгарсан бөгөөд Засгийн газрын хэмнэлтийн тухай бодлогын хүрээнд төсөвт тодотгол хийгдэн хөрөнгө оруулалтыг багасгаж баталсан тул энэ онд төлөвлөгдсөн 140 сая төгрөгөөр сүм тус бүрт цахилгааны дизель генераторыг хүлээлгэж өгсөн бөгөөд 2023 оны үлдэгдэл санхүүжилтээр шугам сүлжээний өргөтгөлийг гүйцэтгэнэ.	50	
5.1.3			1,550.0	750.0		Дашинчилэн суманд сумын хөгжил төслийг эхлүүлж, Орхон, Хангал, Бүрэгхангай суманд даралтат цамхаг барина.	Бүрэгхангай, Орхон, Хангал сумын төвд тус бүр 250 сая төгрөгөөр цэвэр усны даралтат усан сангийн барилга гүний худгийн байгууламжийн хамт гүйцэтгэж ашиглалтад оруулаад байна.	100	
5.1.4	ЗДМХ-5.1.5	Сумын төвийн инженерийн хангамж, дэд бүтцийг сайжруулах	779.0	779.0	Сайхан, Баян-Агт суманд инженерийн шугам ажлын гүйцэтгэсэн.	Орхон, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, сумын инженерийн хангамжийг сайжруулна.	Аймгийн орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгөөр Сайхан сумын төвийн цэвэр усны төвлөрсөн системийн 3 дугаар шатны ажлыг гүйцэтгэх бөгөөд нийт 700 м, Ф100 мм-ийн шугам, 1ш ундны ус түгээх ухаалаг худаг угсрах юм. Уг ажилд "Тэнгэр хишиг" ХХК шалгаран 2021 оны 08 сарын 25-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажил нь 2021-2022 онд дамнан хэрэгжих төсөл бөгөөд 2022 оны 08 дугаар сарын 28-нд ашиглалтад оруулсан. Баян-Агт сумын төвийн цэвэр усны эх үүсвэр 60 м3 усан сан, 670 м цэвэр усны гол шугамын угсралтын ажлыг "Хөх тавилан" ХХК гүйцэтгэж 2021 онд ашиглалтад хүлээлгэж өгсөн.	100	
5.1.5	БАХҮЧ-4.1, ЗДМХ-5.1.4	Хутаг-Өндөр сумын төвийн үерийн байгууламжийн ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж ажлыг үргэлжлүүлэх	1,966.0	800.0	Эхлэл, төгсгөлийн үерийн байгууламжийг барьсан.	3,4-р сувгийн ажлыг гүйцэтгэнэ.	Хутаг-Өндөр сумын төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Хангилцаг ХХК шалгаран, 4.279.566.403 төгрөгөөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн, 2022-2023 онд он дамнан хэрэгжих бөгөөд энэ оны ажлын гүйцэтгэл 70 хувьтай ажил үргэлжилж байна.	100	
5.1.6	БАХҮЧ-4.1, ЗДМХ-5.1.4	Сайхан сумын үерийн далангийн ажлын зураг төслийг гүйцэтгэж, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	1,400.0	200.0	Сайхан сумын үерийн далангийн ажил хийгдэж байна.	Сайхан сумын үерийн далангийн ажлыг эхлүүлсэн байна.	Сайхан сумын төвийн үерийн хамгаалалтын далангийн ажлын гүйцэтгэгчээр "Хайдро проект" ХХК шалгаран 2020 онд 426.788.914 төгрөгөөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн, ажлын гүйцэтгэл 70 хувьтай, ажил гүйцэтгэх явцад үер буусны улмаас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орж, Барилга, хот байгуулалтын яаманд нэмэлт санхүүжилтийн асуудлаар хандсан бөгөөд 2022 онд БХБ-ын сайдын багцаас 200.0 сая төгрөг шийдвэрлүүлсэн бөгөөд далан сувгийн ажил үргэлжлэн хийгдэж ашиглалтад орно.	70	
5.1.7	ЗГҮАХ-3.6.1, ЗДМХ-5.1.6	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлэх	10,590.0	1,270.8	34.8 км хатуу хучилттай авто зам барьсан.	31.08 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто замын ажлын үргэлжлэлийн хөрөнгө оруулалт болох 31.08 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 1270.8 сая төгрөг тусгаж, ажлын гүйцэтгэгчээр "РЭС" ХХК шалгарч Зам тээврийн хөгжлийн төвтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ оны авто замын төлөвлөгөөт ажлыг эхлүүлээд байна.	100	
5.1.8	ЗДМХ-5.1.6	Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулах	2,000.0	2,000.0	10 км авто зам барих 5000,0 сая төгрөг батлагдсан.	Хялганатын замын ажлыг график, төлөвлөгөөний дагуу хийнэ.	Аймгийн Засаг даргын 2022.09.19-ны өдрийн 01/1046 тоот албан бичгээр Эрдэнэт хотоос – Хангал сумын төв хүртэлх орон нутгийн чанартай 30 км авто замын ажлын гүйцэтгэгч "Замын битум" ХХК ББЭЗ-63-13/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл 2022.08.11-ны өдөр олгосон, Хангал сумын төвөөс – Хялганат тосгоны төмөр бетон гүүр хүртэлх 23.6 км авто замын ажил гүйцэтгэгч "Хурдны зам" ХХК-д ББЭЗ-63-05 дугаартай зөвшөөрөл 2022.06.20-ны өдөр олгосон, Хангал сумаас Хялганат тосгон хүртэлх авто замын дундаас Эрдэнэт үйлдвэрийн "Сэлэнгэ" амралтын бааз, Олимпын тамирчдын бэлтгэлийн бааз буюу 1-р подем чиглэлийн 10.4 км авто замын ажлын гүйцэтгэгч "Жавхлант харгуй" ХХК-д 2022.09.27-ны өдөр ББЭЗ-63-16/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Хялганат тосгоны төвийн 10 км авто замын гүйцэтгэгч "Увт инвест" ХХК-ны ажил энэ сарын байдлаар дуусаж явган замын хавтан суулгах, гэрэлтүүлэгийн ажил гүйцэтгэж байна.	90	
5.1.9	ЗДМХ-5.1.7	Багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ бий болгох	950.0	350.0	19 багийг сүлжээнд холбосон.	5 багийг сүлжээнд холбоно.	2022 онд Юнител компани Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 14 багийг шинээр сүлжээнд холбосон. Мөн Булган сумын 6Д хороолол болон 3 дугаар баг, "Жаргалант" зуслан гэсэн 3 газарт шинээр цамхаг босгож, сүлжээний өргөтгөл хийв. Мобиком компани Орхон сумын Халиун багт, Сайхан сумын Угалз, Ундрах гэх 3 багт шинээр сүлжээний цамхаг босгон ашиглалтад оруулснаар энэ онд нийт 20 байршил үүрэн холбооны сүлжээнд холбогдлоо.	100	
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ								84.4	

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР